



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/84

Эрдэнэт

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын "Шар түвшин"-д шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.2, 27<sup>1</sup>.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйлийн 7<sup>1</sup>.1, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2022 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэргийг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс цуцалж, Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын "Шар түвшин"-д шилжүүлсүгэй.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, журам, халдвар хамгааллын дэглэмийг бүх шатанд тогтмол хэрэгжүүлэн ажиллахыг иргэн, төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Соёл, урлаг, биеийн тамирын уралдаан, тэмцээнийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулахыг Биеийн тамир спортын газар (Д.Дэлгэрбаяр), Боловсрол, шинжлэх ухааны газар (О.Ариунгэрэлт), Соёл урлагийн газар (А.Уранчимэг), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр)-нд тус тус даалгасугай.

4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг хариу арга хэмжээний үйл ажиллагааг эрчимжүүлэх, өвчлөлийг тандалтад суурилан өрх, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр ангилан голомтыг цомхотгох, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, эмч, эмнэлгийн ажилчдын хариуцлагыг дээшлүүлэн, өвчтөнд тавих хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Ц.Наран-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансор, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/745 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ



D:\zahirami/A-4.doc

6122020509